

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ ГУРАВДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2018 оны нэгдүгээр сарын 25-ний 14 цаг 10 минутад эхэлж, 15 цаг 15 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д 1 цаг 05 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулсан Комиссын танилцуулга	
2	Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэр, Сонгон шалгаруулах комиссын 2017 оны НСШ/32 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн : 1. Аятханы Баймухан, Рахметын Серикбол, Хуанганы Тилеген нарыг Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх 2. Хуанганы Тилегенийг Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Баян-Өлгий аймгийн Засаг дарга /А.Гылымхан/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.
3	Говь-Алтай аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн	Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн

<p>жинхэнэ албан тушаалын сул орон тоо нөхөх мэргэшлийн шалгалтын дүн</p>	<p>албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйл, Төрийн албаны мэргэшлийн шалгалтын Төв комиссын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний 01 дугаар тогтоолыг тус тус үндэслэн, Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаас:</p> <ol style="list-style-type: none"><li data-bbox="836 598 1421 1144">1. Төрийн албаны зөвлөлийн Говь-Алтай аймаг дахь Салбар зөвлөлөөс 2017 оны 12 сард зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 47 иргэнийг “дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 25 иргэнийг “туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх<li data-bbox="836 1144 1421 1690">2. Энэхүү тогтоолын нэгд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс гуравдугаар хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 15 иргэн, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс дөрөвдүгээр хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 10 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх<li data-bbox="836 1690 1421 1873">3. Тогтоолын хоёр, гуравт дурдсан нэр бүхий 25 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан
---	--

		<p>сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Говь-Алтай аймаг дахь Салбар зөвлөл /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгох</p> <p>4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба /Д.Баатарсайхан/-нд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
--	--	--

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА**